



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 07 сарын 09 өдөр

Дугаар 0/402

Улаанбаатар хот

┌ Хан-Уул дүүргийн 10 дугаар сургуулийн ┐
барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 109 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/924 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн хуучин барилгыг буулгаж шинэ барилга барихтай холбогдуулан Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагчийн 2013 оны 02-07-80/277 тоот дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Хан-Уул дүүргийн 10 дугаар сургуулийн балансад бүртгэлтэй хавсралтад заасан нийт 132,867,127.56 /нэг зуун гучин хоёр сая найман зуун жаран долоон мянга, нэг зуун хорин долоон төгрөг тавин зургаан мөнгө/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг акталж, нийслэлийн өмчийн бүртгэлээс хасч, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Хан-Уул дүүргийн 10 дугаар сургууль /А.Туяасайхан/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй барилгын хоёрдогч түүхий эдийн зориулалтаар дахин ашиглах боломжтой хөрөнгийг худалдан борлуулахаар үнэлсэн 11,902,100 /арван нэгэн сая есөн зуун хоёр мянга нэг зуун/ төгрөгийг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга /Д.Рэнцэнбямба/-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ




Ш.ҮНЭНБАТ



1119282495 2576589

115050000953

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
 даргын 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн
 7/09 дугаар тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА
 БАЙГУУЛАМЖ, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХӨРӨНГӨ

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Биет хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэх өртөг |
|----------|-------------------|---------------|-------------|-------------|---------------|----------------|--------------------|---------------|
| 1 | Барилга | 57 | м2 | 1560.6 | 58,064,324.36 | 58,064,324.36 | 36,290,202.75 | 21,774,121.61 |
| 2 | Сургуулийн талбай | 1 | м2 | 780.3 | 28,831,250.00 | 28,831,250.00 | 4,004,340.30 | 24,826,909.70 |
| 3 | Мод | 25 | ш | 25 | 7,450.00 | 186,250.00 | - | 186,250.00 |
| 4 | Хашаа | 1 | ш | 1 | 1,058,803.20 | 1,058,803.20 | 63,024.00 | 995,779.20 |
| 5 | Дулааны шугам | 35 | м | 120 | 290,325.00 | 34,839,000.00 | 3,629,062.50 | 31,209,937.50 |
| 6 | Бохирын шугам | 15 | м | 123 | 28,682.93 | 3,528,000.00 | 630,000.00 | 2,898,000.00 |
| 7 | Цэвэр усны шугам | 15 | м | 120 | 52,995.83 | 6,359,500.00 | 1,135,624.95 | 5,223,875.05 |
| Нийт дүн | | | | | | 132,867,127.56 | 45,752,254.50 | 87,114,873.06 |